АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2025/030/-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор Л.Соёлмөнх<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 64

танай ______________-ны №______________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Э.БӨХБААТАР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Цалингийн сангаас 15,925.7 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон.
2. Албан хаагчдад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллыг зөрүүтэй тооцож олгосон.
3. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалт бус зарцуулсан.

Эдгээр зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйл, 2024 оны 83 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-тай нийцээгүй бөгөөд санхүүгийн

тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь тайлант онд 1,898,102.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,695,598.0 мянган төгрөгийг зарцуулж, 202,504.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 250 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан 150 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 79 арга хэмжээ 90 хувь, 21 арга хэмжээ 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс 74.8 хувьтай үнэлэгдсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **82,695,619.40** | **88,035,683.40** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **82,695,619.40** | **88,035,683.40** |
| **351** | **Түүхий эд материал** | **28,432,305.00** | **32,390,305.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 28,432,305.00 | 32,390,305.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **54,263,314.40** | **55,645,378.40** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,841,596.00 | 430,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 52,421,718.40 | 53,119,498.40 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 1,895,880.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 200,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,588,240,552.77** | **2,941,093,323.52** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,588,240,552.77** | **2,941,093,323.52** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,569,998,552.77** | **2,901,176,323.52** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 805,073,393.00 | 1,412,163,493.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (244,729,104.70) | (303,006,913.21) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 307,275,705.00 | 331,189,970.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (174,954,342.73) | (152,589,190.48) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 136,147,854.64 | 149,341,332.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (89,140,463.63) | (71,577,527.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 77,232,936.77 | 68,227,150.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (55,653,829.52) | (22,035,983.99) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 614,733,758.00 | 830,853,758.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (355,418,175.24) | (399,684,866.20) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,038,773,440.10 | 1,343,399,654.02 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (707,860,563.92) | (532,139,197.19) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 218,667,945.00 | 218,667,945.00 |
| 39217 | Ном | - | 28,516,700.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **18,092,000.00** | **39,767,000.00** |
| 39301 | Программ хангамж | 6,797,000.00 | 6,797,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,797,000.00) | (6,797,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,092,000.00 | 39,767,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,670,936,172.17** | **3,029,129,006.92** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,670,936,172.17** | **3,029,129,006.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,670,936,172.17 | 3,029,129,006.92 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 526,050,422.68 | 526,050,422.68 |
| 51101 | Өмч: - төрийн | 526,050,422.68 | 526,050,422.68 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **913,137,766.51** | **2,271,330,601.51** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 913,137,766.51 | 913,137,766.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,358,192,834.75 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 231,747,982.98 | 231,747,982.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,670,936,172.17** | **3,029,129,006.92** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,014,784,593.00** | **3,261,354,292.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,189,918.00** | **1,363,757,863.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **46,189,918.00** | **1,363,757,863.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 493,800.00 | 505,692.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 493,800.00 | 505,692.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлог-Үндсэн хөрөнгө | 45,696,118.00 | 1,363,252,171.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **968,594,675.00** | **1,897,579,729.05** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,625,875.00** | **62,133,129.05** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 6,050,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,625,875.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,122,638.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 53,960,491.05 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **963,968,800.00** | **1,835,463,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 963,968,800.00 | 1,835,463,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,230,945,335.37** | **1,903,161,457.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,230,945,335.37** | **1,903,161,457.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,080,835,579.08** | **1,656,565,459.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **416,243,985.09** | **637,600,907.25** |
| 210101 | Үндсэн цалин | 311,070,656.54 | 416,995,434.18 |
| 210102 | Нэмэгдэл | 57,160,370.85 | 181,168,699.07 |
| 210104 | Урамшуулал | 32,663,907.91 | 31,638,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,349,049.79 | 7,798,374.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **53,456,358.62** | **78,775,285.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,824,460.61 | 55,072,333.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,623,966.45 | 6,368,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,135,082.24 | 5,016,333.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 651,241.24 | 1,073,794.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,221,608.08 | 11,243,923.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,311,650.00** | **29,819,294.83** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,000,000.00 | 19,279,294.83 |
| 210302 | Түлш, халаалт | 7,311,650.00 | 10,540,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **65,831,515.00** | **58,337,226.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,149,000.00 | 5,888,896.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 53,972,765.00 | 39,999,630.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,355,000.00 | 5,558,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 1,500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,354,750.00 | 5,390,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,515,600.00** | **49,718,570.00** |
| 210604 | Урсгал засвар | 9,515,600.00 | 49,718,570.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,215,500.00** | **8,941,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,215,500.00 | 8,941,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,977,779.00** | **7,918,447.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,477,779.00 | 6,492,638.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 500,000.00 | 1,425,809.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **502,283,191.37** | **785,454,729.25** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 216,538,035.00 | 515,783,229.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 700,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 285,745,156.37 | 265,971,000.25 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **150,109,756.29** | **246,595,997.90** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,671,900.00** | **44,091,900.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 20,400,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,520,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,671,900.00 | 9,171,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **137,437,856.29** | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 137,437,856.29 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **202,504,097.90** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 175,270,968.85 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 27,233,129.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(261,856,860.37)** | **1,358,192,834.75** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(261,856,860.37)** | **1,358,192,834.75** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **969,088,475.00** | **1,898,102,121.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **493,800.00** | **505,692.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 493,800.00 | 505,692.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 493,800.00 | 505,692.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 493,800.00 | 505,692.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **968,594,675.00** | **1,897,596,429.05** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,625,875.00 | 62,133,129.05 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 6,050,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,625,875.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,122,638.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 53,960,491.05 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 963,968,800.00 | 1,835,463,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 963,968,800.00 | 1,835,463,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **933,288,475.00** | **1,639,530,521.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **933,288,475.00** | **1,639,530,521.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **783,178,718.71** | **1,392,934,523.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **417,552,068.91** | **637,600,907.25** |
| 210101 | Үндсэн цалин | 303,252,915.33 | 416,995,434.18 |
| 210102 | Нэмэгдэл | 70,109,321.46 | 181,168,699.07 |
| 210104 | Урамшуулал | 31,389,832.12 | 31,638,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 12,800,000.00 | 7,798,374.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **51,648,274.80** | **78,775,285.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,212,175.61 | 55,072,333.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,260,260.84 | 6,368,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,355,408.24 | 5,016,333.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 696,357.24 | 1,073,794.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,124,072.87 | 11,243,923.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,040,000.00** | **29,819,294.83** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,000,000.00 | 19,279,294.83 |
| 210302 | Түлш, халаалт | 7,040,000.00 | 10,540,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **46,208,496.00** | **57,125,630.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,948,096.00 | 4,477,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,000,000.00 | 39,999,630.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,400,000.00 | 5,758,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 1,500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,860,400.00 | 5,390,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,365,600.00** | **22,094,350.00** |
| 210604 | Урсгал засвар | 9,365,600.00 | 22,094,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,215,500.00** | **8,941,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,215,500.00 | 8,941,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,977,779.00** | **7,918,447.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,477,779.00 | 6,492,638.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 500,000.00 | 1,425,809.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **225,171,000.00** | **550,659,609.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 225,171,000.00 | 549,959,109.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 700,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **150,109,756.29** | **246,595.997.90** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,671,900.00** | **44,091,900.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 20,400,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,520,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,671,900.00 | 9,171,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **137,437,856.29** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 137,437,856.29 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **202,504.097.90** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 175,270,968.85 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 27,233,129.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **35,800,000.00** | **258,571,600.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **35,800,000.00** | **258,571,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **35,800,000.00** | **258,571,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 35,800,000.00 | 258,571,600.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 35,800,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 258,571,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(35,800,000.00)** | **(258,571,600.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **526,050,422.68** | **231,747,892.98** | **1,129,298,508.88** | **1,887,096,914.54** |
| 2 | Тайлант үеийн үр дүн | | | (216,160,742.37) | (216,160,742.37) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **526,050,422.68** | **231,747,982.98** | **913,137,766.51** | **1,670,936,172.17** |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | | 1,358,192,834.75 | 1,358,192,834.75 |
| 10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **526,050,422.68** | **231,747,982.98** | **2,271,330,601.26** | **3,029,129,006.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,835,633,300.00** | **1,660,698,023.15** | **174,935,276.85** | **90.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,694,366,600.00** | **1,519,519,923.15** | **174,846,676.85** | **89.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,650,274,700.00** | **1,475,428,023.15** | **174,846,676.85** | **89.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **702,234,300.00** | **637,600,907.25** | **64,633,392.75** | **90.80** |
| 210101 | Үндсэн цалин | 619,029,700.00 | 416,995,434.18 | 202,034,265.82 | 67.36 |
| 210102 | Нэмэгдэл | 60,007,300.00 | 181,168,699.07 | (121,161,399.07) | 301.91 |
| 210104 | Урамшуулал | - | 31,638,400.00 | (31,638,400.00) | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,197,300.00 | 7,798,374.00 | 15,398,926.00 | 33.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **94,310,300.00** | **78,775,285.07** | **15,535,014.93** | **83.53** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,837,200.00 | 55,072,333.33 | 13,764,866.67 | 80.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,368,900.00 | 6,368,900.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,094,500.00 | 5,016,333.44 | 78,166.56 | 98.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,273,600.00 | 1,073,794.58 | 199,805.42 | 84.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,736,100.00 | 11,243,923.72 | 1,492,176.28 | 88.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30,540,000.00** | **29,819,294.83** | **720,705.17** | **97.64** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,000,000.00 | 19,279,294.83 | 720,705.17 | 96.40 |
| 210302 | Түлш, халаалт | 10,540,000.00 | 10,540,000.00 | - | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **58,685,600.00** | **57,125,630.00** | **1,559,970.00** | **97.34** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,500,000.00 | 4,477,300.00 | 22,700.00 | 99.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,000,000.00 | 39,999,630.00 | 370.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,000,000.00 | 5,758,000.00 | 242,000.00 | 95.97 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,685,600.00 | 5,390,700.00 | 1,294,900.00 | 80.63 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **37,000,000.00** | **30,299,350.00** | **6,700,650.00** | **81.89** |
| 210602 | Тавилга | 15,000,000.00 | 8,205,000.00 | 6,795,000.00 | 54.70 |
| 210604 | Урсгал засвар | 22,000,000.00 | 22,094,350.00 | (94,350.00) | 100.43 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **10,434,200.00** | **8,941,000.00** | **1,493,200.00** | **85.69** |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,434,200.00 | 8,941,000.00 | 1,493,200.00 | 85.69 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **18,700,000.00** | **7,918,447.00** | **10,781,553.00** | **42.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,400,000.00 | 6,492,638.00 | 7,907,362.00 | 45.09 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - | 500,000.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 3,800,000.00 | 1,425,809.00 | 2,374,191.00 | 37.52 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **698,370,300.00** | **624,948,109.00** | **73,422,191.00** | **89.49** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 696,870,300.00 | 624,247,609.00 | 72,622,691.00 | 89.58 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 700,500.00 | 799,500.00 | 46.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,091,900.00** | **44,091,900.00** | **-** | **100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **44,091,900.00** | **44,091,900.00** | **-** | **100.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,400,000.00 | 20,400,000.00 | - | 100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,520,000.00 | 14,520,000.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,171,900.00 | 9,171,900.00 | - | 100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **141,266,700.00** | **141,178,100.00** | **88,600.00** | **99.94** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **141,266,700.00** | **141,178,100.00** | **88,600.00** | **99.94** |
| 220001 | Барилга байгууламж | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 74,500,000.00 | 74,485,000.00 | 15,000.00 | 99.98 |
| 223001 | Бусад хөрөнгө | 46,766,700.00 | 46,693,100.00 | 73,600.00 | 99.84 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,835,633,300.00** | **1,835,952,292.00** | **318,992.00** | **100.02** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,835,463,300.00** | **1,835,446,600.00** | **16,700.00** | **100.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,835,463,300.00 | 1,835,446,600.00 | 16,700.00 | 100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **170,000.00** | **505,692.00** | **(335,692.00)** | **-** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 505,692.00 | (505,692.00) | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **28.00** | **28.00** | **-** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 8.00 | 8.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 | - | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **62,133,129.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **62,133,129.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | **34,900,000.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | **34,900,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 34,900,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 27,233,129.05 |
| 2132 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 27,233,129.05 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **62,133,129.05** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **62,133,129.05** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 6,050,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 20,622,638.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 35,460,491.05 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **351,801.3** мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 351,801.3 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Азийн хөгжлийн банкны зээлээр Засгийн газар болон Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа төсвийн санхүүгийн удирдлагын ил тод үр ашигтай байдал төслөөс 2,574.4 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг орлогод авч, бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан нь УСНББОУС 1, 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайлан болон үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд залруулга хийлгэлээ.
2. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн урсгал зардлын шинжтэй 349,226.8 мянган төгрөгийн ажлыг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаж буруу илэрхийлсэн нь УСНББОУС 1, 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайлан болон үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 93,543.1 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 6,716.4 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 86,826.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 93,543.1 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **20,650.9** мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1** Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллыг 6 албан хаагчид олгохдоо сүүлийн сарын үндсэн цалинг 6 дахин нэмэгдүүлж тооцон 2,719.2 мянган төгрөгийг илүү олгосон ба 1,311.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-т "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.1.2** Хавсран ажилласны болон орон нутгийн нэмэгдлийг 1,302.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.1.3** Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ажил гүйцэтгүүлсний хөлсөнд 2,800.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулалд 4,000.0 мянган төгрөгийг олгохдоо 782.0 мянган төгрөгийн НДШ болон 601.8 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж аваагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна: 19.1.2-т Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс; 19.1.3-т ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

**5.2.1** Жаргалант сумын Засаг даргын 2024 оны Б/12 дугаар захирамжаар 5 багийн Засаг даргад нийт 6,943.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, 7 албан хаагчдад 8,982.0 мянган төгрөгийн шагнал, тэтгэмж цалингийн сангаас олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг таслан зогсоож, шагнал урамшууллыг цалингийн сангаас олгосон зөрчлийг таслан зогсоож, зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

**5.2.2** Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 69,688.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаал, 2018 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн 134 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийг мөрдөж, зардлыг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүллээ.

**5.2.3** Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмнээний зардлаас ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д хамаарахгүй 26 арга хэмжээнд 391,904.5 мянган төгрөгийн төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 359,227.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", ЗГ-ын 2022 оны 2-р тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6.1-3.6.18 дахь заалтыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийн 6.5.5 дахь заалт, ЗГ-ын 2022 оны 2-р тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүллээ.

**5.2.4** Нийгмийн даатгалын тайланг цалин, шимтгэлтэй тулган шалгахад 1 дүгээр сард 1145.3 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнаж 263.4 мянга, хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн 62.7 мянган төгрөгийн НДШ дутуу төлсөн, мөн 3, 4 дүгээр сард 3,854.4 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнаж, 886.4 мянган төгрөгийн НДШ илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг таслан зогсоож, НДШ-ийн авлагыг барагдуулах ажиллах албан шаардлага хүргүүллээ.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төслөөс олгосон хөрөнгийг орлогод авч бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан | 1 | 2,574.4 | 1 | 2,574.4 | | | 1 | 2,574.4 | | | | |
| Урсгал зардлыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн | 1 | 349,226.8 | | | 1 | 349,226.8 | 1 | 349,226.8 | | | | |
| **Нийт дүн** | **2** | **351,801.3** | **1** | **2,574.4** | **1** | **349,226.8** | **1** | **351,801.3** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хөдөө орон нутгийн тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж илүү олгосон. | 1 | 4,030.4 | 1 | 4,030.4 | | | | | | | | |
| Нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон | 1 | 1,302.2 | 1 | 1,302.2 | | | | | | | | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс НДШ, ХХОАТ суутгаж аваагүй. | 1 | 1,383.8 | 1 | 1,383.8 | | | | | | | | |
| Цалингийн сангаас шагнал, урамшуулал олгосон | 1 | 15,925.7 | | | 1 | 15,925.7 | | | | | | |
| Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн | 1 | 69,688.5 | | | 1 | 69,688.5 | | | | | | |
| Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын | 1 | - | | | 1 | - | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| дагуу зарцуулаагүй | | | | | | | | | | | | |
| НДШ-ийг илүү дутуу тооцож олгосон | 1 | 1,212.5 | | | 1 | 1,212.5 | | | | | | |
| **Нийт дүн** | **7** | **93,543.1** | **3** | **6,716.4** | **4** | **86,826.7** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн данс | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |